


GoGo.mn-ээс Мобикомын хэрэглэгч рүү мессеж илгээх эрхийг цэнэглэх боломжтой боллоо.

GoGo.mn-ийн хэрэглэгчид Мобикомын хэрэглэгчдээс мессеж хүлээн авах бүрт GoGo.mn-ээс мессеж илгээх эрхтэй болдог билээ. Бид хэрэглэгчдийн хүсэлтээр мессеж илгээх эрхийг цэнэглэх боломжтой болголоо. Цэнэглэлт Мобикомын хэрэглэгчийн гар утаснаас хийгдэнэ.

Мобикомын хэрэглэгч Та GoGo.mn-ийн гишүүн хэрэглэгчдийн мессеж илгээх эрхийг 10-30 эрхээр цэнэглэх боломжтой. Цэнэглэх төлбөр Таны утсан дахь нэгжээр хийгдэнэ.

Цэнэглэх заавар:

GoGo.mn-ийн хэрэглэгчийн дансыг 10 мессеж илгээх эрхээр цэнэглэх бол тухайн хэрэглэгчийн 511xxxxxx дугаарыг бичээд зай аваад 10 гэж бичээд 511 дугаарт илгээнэ.



Үнэ тариф:

511 тусгай дугаарт илгээсэн SMS-ийн үнэ нь энгийн SMS-ийн тарифтай адил байна.

Харин GoGo.mn-ийн хэрэглэгчийн дансыг

10 нэгжээр цэнэглэхэд **290 нэгж**/төгрөг/ **511xxxxxx 10 гэж бичээд 511 дугаарт илгээнэ**

20 нэгжээр цэнэглэхэд **575 нэгж**/төгрөг/ **511xxxxxx 20 гэж бичээд 511 дугаарт илгээнэ**

30 нэгжээр цэнэглэхэд **860 нэгж**/төгрөг/байна. **511xxxxxx 30 гэж бичээд 511 дугаарт илгээнэ**

Үйлчилгээг хаах:

Хэрвээ Мобикомын хэрэглэгч Та GoGo.mn-ийн 511xxxxxx дугаар бүхий хэрэглэгчээс мессеж хүлээн авах хүсэлтгүй бол;

511 тусгай дугаарт дараах командуудыг илгээх боломжтой.

- * **Block** – 511xxxxxx дугаараас SMS хүлээн авах эрхээ хаах
- * **Unblock** - 511xxxxxx дугаараас SMS хүлээн авах эрхээ сэргээх
- * **Status** - 511xxxxxx дугаараас SMS хүлээн авах эрхийн тайлбарыг харах
- * **Help** –ийг илгээснээр дээрх 3 командын зааварчилгааг хүлээн авах болно.